



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/239

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.а, 29.1.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн гуравдугаар хуралдааны 3/03 дугаар төсөв батлах тухай тогтоолын 4.28 дахь хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 02 дугаар тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Амарсанаагийн цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт, нийтийн ариун цэврийн байгууламж байгуулах ажилд зориулан 345.2 сая төгрөг /гурван зуун дөчин таван сая хоёр зуун мянган/ -ийг хавсралтаар батлан зарцуулсугай.

2.Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль журмын дагуу шуурхай зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/, хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, худалдан авах ажиллагааны албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Батсүх/ нарт үүрэг болгосугай.

3.Дээрх төсөл арга хэмжээний зардлыг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 4.28-д тусгагдсан “Аймаг байгуулагдсаны 90 жилийн ой, Ардын хувьсгалын 100 жилийн ой угтсан бүтээлч ажил, тохижилт, засвар үйлчилгээ, бүтээн байгуулалт, төсөл арга хэмжээний зардал”-аас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

Zax A/239 Ch

02 1286

4. Төсөл арга хэмжээний захиалагчийн техникийн хяналт хийж тайлагнахыг Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Жаргалант сумын Засаг дарга /Ц.Цогтбаяр/-д үүрэг болгосугай.


5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны
05 дугаар сарын 20-ны өдрийн
239 дүгээр захирамжийн хавсралт



АМАРСАНААГИЙН ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭНГИЙН ТОХИЖИЛТ,
НИЙТИЙН АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖ БАЙГУУЛАХ ТӨСӨЛ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

д/д	Төсөл арга хэмжээ нэр	Төсөв өртөг /сая.т өг/	Санхүү жих дүн
	1. Хөрөнгө оруулалтын нийт дүн	400.8	345.2
	1.1. Амар санаагийн цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт	360.6	305.0
1	Усан оргилуур байгуулах	80.0	80.0
2	Ховдын өв хөшөөт цогцолбор	187.6	132
3	Нийтийн бие засах газар байгуулах	50.0	50.0
4	Явган хүний зам	23.0	23.0
5	Гэрэлтүүлэг	20.0	20.0
	2. Явган зам засвар	26.2	26.2
	3. Нийтийн эзэмшлийн талбайн усалгааг нэмэгдүүлэх	4.0	4.0
	4. Ногоон байгууламж	10.0	10.0

-oOo-